



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 1199

Чойр

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх “Тэр бум мод” тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд ойн зурvas байгуулах /4 га талбайд/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Э.Түвшинзаяа

(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын албаны дарга)

О.Отгонбаяр

(Шивээговь сумын бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Хөндлөнгийн төлөөлөл:

Н.Солонго

(Сүмбэр сумын 3 дугаар багийн  
иргэн)

Нарийн бичгийн дарга:

Г.Энххишиг

(Аймгийн Засаг даргын Тамгын  
газрын Хөгжлийн бодлого,  
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион  
байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ  
байгуулж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч  
хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж эзэмшил ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг  
аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Д.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг  
болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ

